МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,103.549... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.09.06. Мягмар. №157 (4527) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

**АСУУДЛЫН МӨРӨӨР**

ОРХОН ГОЛЫГ БОХИРДУУЛСАН КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООЖ, ХЯНАЛТ ТАВЬЖ ЭХЭЛЛЭЭ

II нүүрт

**ОНЦЛОХ ХУУДАС**

V нүүрт

**ЭДИЙН ЗАСАГЧ ЯРЬЖ БАЙНА**

Дугаарын 60 мөр

## Парламент дахь “харамчийнхан”-аас ганц зүйл хүсье

Б.ДАВАА

Эх орны эдийн засаг элгээрээ хэвтэхэд тун ойртсон тухай мэдээлэл, цочирдом тоо баримтыг Сангийн сайд олонд тунхаглаж, дээр дооргүй бүсээ чангалах үе ирснийг сануулав. Түүний хийсэн мэдэгдлийг Ерөнхий сайдын хасах, танах, хэмнэх тухай мэдэгдлүүд, төв банкны бодлогын хүүгээ өсгөх шийдвэр үндсэндээ баталж орхисон. Улс орны эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, өрийн тоо баримтыг хамгийн сайн мэдэх хүмүүс бол УИХ-ын гишүүд, сайдууд. Харин жирийн иргэдийн хувьд идэх хоол нь хэрхэн багасч, халаас нь нимгэрснээр л улсын нөхцөл байдлыг төсөөлж суугаа гээд хэлчихвэл хэтийдэхгүй. Уг нь энэ засгийн газар тун чиг зоригтой алхам хийхээр зэхэж байлаа. Даанч биелээгүй л болохоос.

Үргэлжлэл нь II нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## ЦЭНГЭЭНИЙ ГАЗРЫН ЦАГААР ОРОЛДОХООС ӨӨР ХИЙХ АЖИЛ АЛГА УУ

Н.ПУНЦАГБОЛД

Нийслэлийн Засаг дарга С.Батболдоос энэ асуултыг асуумаар байна. Өнөөдөр Улаанбаатар хотод цэнгээний газрын цагийг нааш цааш нь болгохоос өөр хийх ажил мундахгүй л их баймаар юм. Яг үнэндээ хотын шинэ дарга С.Батболд ажлаа авснаас хойш дорвитой ажил юу хийв. Ажлын өрөөгөө тохижуулахад улсын мөнгө үрлээ гэх хэрүүлд л хутгалдлаа. Дээрээс нь өмнөх хотын удирдлагуудын хийж, хэрэгжүүлсэн зүйлсийг өөрчлөхөд анхаарлаа. Дамбадаржаа, Дэнжийн 1000 орчмыг хотын дэд төв болгоно ч гэх шиг. Уг нь өмнөх удирдлагууд Ханын материал орчмыг дэд төв болгож, тэнд нийслэлийн шинэ захиргааны барилгыг барина гэж байсан. Үүнийг өөрчилж, Дэнжийн 1000 гэж өөрчилдөг нь ямар ч учиртай юм. Гэх мэтээр бусдын хийснийг баллуурдаж, өөрчлөх л ажил хийж байна. Баар, цэнгээний газар, пабын хаах цагийг наашлуулах талаар албан ёсоор ч биш, твиттер хуудсаараа дамжуулж мэдэгдэл гаргаадахав. Улаанбаатарын баар, цэнгээний газрууд үүрийн 04:00 цаг хүртэл ажиллаж байгаа нь хотын даргад гай болоод байгаа бололтой юм. Хэрвээ үнэхээр иймшийдвэр гаргахаар шийдсэн бол ганц хоёр зөвлөгөө өгөх гэсэн юм, хотын дарга аа.

Үргэлжлэл нь III нүүрт

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**






Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Н.ЭНХБАЯР: БИДЭНД ДОТООДЫНХОО НӨӨЦ БОЛОЛЦООГООР ЭДИЙН ЗАСГАА БОСГОХ БОЛОМЖ БАЙХГҮЙ

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс




| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2200.00 | 2228.00 | ФУНТ | 2884.00 | 2990.00 |
| ЕВРО | 2437.00 | 2509.00 | РУБЛЬ | 32.60 | 35.60 |
| ИЕН | 21.05 | 21.71 | ЮАНЬ | 328.50 | 333.30 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2200.00 | 2233.00 | ФУНТ | 2877.00 | 2988.00 |
| ЕВРО | 2425.00 | 2520.00 | РУБЛЬ | 32.28 | 35.45 |
| ИЕН | 20.90 | 21.78 | ЮАНЬ | 326.00 | 334.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

АСУУДЛЫН МӨРӨӨР

# ОРХОН ГОЛЫГ БОХИРДУУЛСАН КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООЖ, ХЯНАЛТ ТАВЬЖ ЭХЭЛЛЭЭ

Э.ТУУЛ





Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт алт олборлож буй компаниудын буруутай үйл ажиллагаанаас үүдэн Монголын хамгийн урт гол болох Орхон бохирдож, улаан хоормог болсон талаар хэн хүнгүй ярьж буй ч дорвитой арга хэмжээ авч чадахгүй явсаар өдийг хүрсэн билээ. Энэ асуудал одоогоос зургаан жилийн өмнөөс эхтэй бөгөөд тухайн үед Орхон голд бохир цутгасан асуудал гарч, ажлын хэсэг томилогдож байв. Ажлын хэсгийнхэн уг бохирдлыг голын дээд эхүүд болох Шийрт, Улаан голуудын эхэнд "Алтан Дорнод Монгол" болон "Монгол газар" компаниуд алт олборлох үйл ажиллагаа явуулсан нь бохирдуулах гол шалтгаан болжээ гэж үзсэн байдаг. Иймд Орхон голын бохирдлыг арилгах зорилгоор 264 дүгээр тогтоол гээчийг 2010 онд Засгийн газраас гаргасан юм. Тогтоолоор эргэлтийн усан сан, хаягдлын сан дундуур ус урсахгүй болох арга хэмжээг авахуулах болон нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх, бохирдлоос шалтгаалаад байгаль орчинд учирсан хохирлыг тооцуулах, гэм буруутай этгээдүүдээр нөхөн төлүүлэх үүргүүдийг холбогдох газруудад өгсөн нь бий. Гэвч энэ тогтоол анх гарсан зорилгоосоо хазайж, эсрэгээрээ Орхон голыг шалбааг шиг болтол нь бохирдуулж, ард иргэд, мал амьтныг ихээр хордуулах болсон тухай тус голын хөндийг даган суурьшсан иргэд мэдээлж байв. Тодруулбал, тус тогтоол батлагдсанаас хойш "Монголгазар" компани оногдсон үүргээсээ чөлөөлөгдөхийн тулд өөрийн эзэмшлийн газраа 60 шахам жижиг компаниудад жижиглэн худалдаалж, нэгэн зэрэг үйл ажиллагаагаа явуулах болсон байна. Улмаар тэдний ашиглаад гаргасан бохир ус далангаа сэтлэн, гарч бүгд Орхон голд шууд цутгасан учир өнгөрсөн оны наймдугаар сараас эхлэн тус гол улаанаараа эргэлдэж, хүн амьтан ойртож ундаалахын эцэсгүй тамтгаа барсан талаар нутгийн иргэд байнга хэлж, ярьсаар өнөөдрийг хүргэв. Таван аймгийн 134 сум, багийн нутгаар дамнан урсч, Сэлэнгэ голд цутгадаг тус гол өнөөдөр амь нь тасрах дээрээ хүрээд байгааг тус аймгийн удирдлагууд болон нутгийн иргэд хэлж байгаа юм. Зургаан жилийн өмнө улаанаар эргэж байсан тэр л төрх өнөөдөр дахин бий болж, нутгийн иргэдийн ундны ус битгий хэл мал ууж болохгүй болтлоо бохирдоод байна.

Тиймээс Орхон голын бодит байдал, хууль, дүрэм журмыг уландаа гишгэсэн алтны компаниудын үйл ажиллагаа, хариуцсан яам, мэргэжлийн байгууллагуудын авч буй арга хэмжээнд дүгнэлт хийж голын бохирдлыг бууруулах үүрэг, чиглэл бүхий БОАЖЯ, УУЯ, МХЕГ, зарим ТББ-ын хамтарсан ажлын хэсгийг өнгөрсөн сард байгуулжээ. Орхон голын бохирдлыг арилгахаар шуурхай ажиллаж эхэлсэн Ажлын хэсгийнхний дүгнэлт зэргийг үндэслэн БОАЖ-ын сайд Д.Оюунхорол, УИХ-ын гишүүн Я.Содбаатар, Д.Тогтохсүрэн, П.Баатарбилэг, МХЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Цагаанхүү, Архангай, Өвөрхангай аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нар болон холбогдох бусад мэргэжилтэн өнгөрсөн бямба гарагт Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багт ажиллаж, орон нутгийн иргэд, уул уурхайн компаниудын төлөөлөлтэй уулзаж, хэлэлцүүлэг өрнүүллээ. Энэ үеэр тэнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу бичиг баримтаа бүрдүүлэх, нөхөн сэргээлтийн барьцаа төлбөрөө улсын төсөвт байршуулах, гол руу бохир ус орохгүй нөхцөлийг бүрдүүлж, хаалт далангаа барих шаардлага тавьсан байна. Эдгээр шаардлагыг биелүүлтэл нэр бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргасан бөгөөд Архангай, Өвөрхангай аймгийн мэргэжлийн хяналтын газрын байцаагч нар өчигдрөөс газар дээр нь хяналт тавьж ажиллаж байгаа юм байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Я.Содбаатар, Б.Саранчимэг нар бүлгийн дэд даргаар томилогдов

МАН-ын бүлэг өчигдөр хуралдаж, УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга нарыг томилох тухай асуудлыг хэлэлцсэн билээ. Бүлгийн хурлын өмнө МАН-ын Удирдах зөвлөл хуралдаж, бүлгийн дэд даргаар хэнийг томилох тухай ярилцсан бөгөөд бүлгийн хурлаар уг асуудлыг хэлэлцээд, Я.Содбаатар, Б.Саранчимэг нарыг томилсон байна. МАН-ын бүлгийн дэд даргаар томилогдсон Янгугийн Содбаатар нь 1997-1999 онд ШУА-ийн харьяа Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1999-2005 онд Монголын Ардчилсан Социалист Залуучуудын Холбоонд нарийн бичгийн дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, 2005-2006 онд Үйлдвэр худалдааны сайдын зөвлөх, 2006-2008 онд Үйлдвэр худалдааны дэд сайд, 2009-2010 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга, дарга, 2010-2012 онд Монгол Ардын Намын Нарийн бичгийн дарга, 2012 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Харин Батсүхийн Саранчимэг нь 1994 онд УИХ-ын Тамгын газарт компьютер сүлжээ хариуцсан администратор, 2006 - 2009 онд "Шинэ зууны УБ" ТББ-ын тэргүүн, 2010 - 2015 онд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн нийслэлийн төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, 2011 оноос Нийслэлийн нийгмийн ардчилал монголын эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн, 2015 онд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын зөвлөх, 2016 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байгаа юм. Мөн МАН бүлгийн хуралдаанаараа төсвийн тодотгол, Ерөнхийлөгчийн хоригтой холбоотой асуудлыг хэлэлцжээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өчигдөр УИХ-ын 26 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьсан бөгөөд уг тогтоолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг буцаах тухай асуудал багтаж байгаа юм.

## Ю.Цэдэнбалын нэрэмжит танхимтай болох санал хүргүүлэв

УИХ-ын гишүүн О.Баасанхүү М.Энхболд даргад хандан, санал хүргүүллээ. Тэрбээр УИХ-ын хуралдааны В танхимыг төр нийгмийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбалын нэрэмжит болгохыг санаачилжээ. Учир нь байнгын хорооны хуралдааны А танхим нь Эзэн Чингис хааны нэрэмжит болгосон бол Б танхимыг жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит болгосон. Тиймээс В танхимыг Ю.Цэдэнбалын нэрэмжит болгох нь зүйтэй хэмээн УИХ-ын гишүүн О.Баасанхүү үзэж, ийнхүү санал гаргасан ажээ.




Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өчигдөр "Рио-2016" зуны олимпийн наадмын мөнгөн медальт, жүдо бөхийн тамирчин Д.Сумъяа, олимпийн хүрэл медальт боксын спортын тамирчин Д.Отгондалай болон олимпийн тэмцээнээс дуулиан дагуулсан чөлөөт бөхийн тамирчин Г.Мандахнаран, дасгалжуулагч Ц.Цогтбаяр, Б.Баяраанарыгхүлээнавчуулзлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж олимпийн наадмын мөнгөн медальт тамирчин Д.Сумъяа, олимпийн хүрэл медальт тамирчин Д.Отгондалай нарт баяр хүргэж, Монголын ард түмэн тэднээс улам их амжилт хүлээж байгааг хэлэв. Тэд хоёулаа "Хилчин" спорт хорооны тамирчид бөгөөд анх олимпийн тамирчдыг үдэж мордуулахад тамирчдаа төлөөлөн тангараг өргөсөн юм. Тангараг өргөсөн хоёр тамирчин хоёулаа олимпийн медаль хүртсэнд Монгол Улсын Ерөнхийлөгч бэлгэшээж буйгаа энэ үеэр мөн хэлсэн. Түүнчлэн чөлөөт бөхийн тамирчин Г.Мандахнаран, дасгалжуулагч Ц.Цогтбаяр, Б.Баяраа нарыг хүлээн авч уулзахдаа спортын авлигын эсрэг, шударга ёсны төлөө тэдний хийсэн тэмцлийг үнэлж буйгаа хэлж, цаашид спортын талбарт илүү их амжилт гаргахыг хүслээ.

Дугаарын 60 мөр

## Парламент дахь "Харамчийнхан"-аас ганц зүйл хүсье

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Түрүүч нь I нүүрт

Төрийн өмчийн компанийн дарга нарын толгой эргэм цалинг хасах тухай мэдэгдлийг хийсэн атлаа яагаад ч юм ухарсан. Харин түүний оронд иргэдэд олгох халамжийг танаж, татварыг нь нэмэгдүүлэхэд анхаарч эхлэв. Татвар, халамжийн дуулиан дэгдэхтэй зэрэгцэн эрхэм гишүүдийн унааны зардлын баримт анхаарал татаж эхэлсэн нь нууц биш. Тодруулбал, 2016 оны долдугаар сарын 28-нд УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон, нягтлан бодогч Л.Хосбаяр нарын гарын үсэг бүхий 32.223.571 төгрөгийн зардал гаргасны гүйлгээний баримт ил болсон. Энэ нь УИХ-ын гишүүдийн зургаа, долдугаар сарын унааны зардал байв. Дээрх мөнгөн дүнгийн 5.953.000 төгрөг нь шуудан холбоо, интернэтийн төлбөр, 26.270.571 төгрөг нь тээвэр, шатахууны зардал юм байх. Энэ баримтаас харахад, гишүүн бүр сар тутамд 312-548 мянган төгрөг авдаг болж таарч байгаа юм. Сангийн сайд Б.Чойжилсүрэн ээлжит бус чуулганы хуралдаан дээр хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж, халамжуудаа танахаа хатуухан хэлсэн авч эрхэм гишүүд өөрсдийнх рүүгээ биш, иргэдийн халаас руу өнгийхийг илүүд үзсэн хэвээр. Уг нь МАН-ынхан 85 хувийг бүрдүүлэх шинэ парламентад Монголын толгой баячууд нэлээд хэд бий. Улс орны эдийн засгийн байдлыг хамгийн сайн мэдэх Сангийн сайд Б.Чойжилсүрэн ч үүнд багтана. Түүнийг гишүүн гэдгээр нь бус, "Хурд" группийн эзэн гэдгээр нь хүмүүс андахгүй. МАК-ийн Н.Номтойбаяр байна. Түүнийг амьд "АТМ" гэж нэрлэх нь бий. "MCS" группийн дэд Ерөнхийлөгч Л.Элдэв-Очир, "Монполимент"-ын Ц.Гарамжав, "Алтай трейдинг"-ийн Сү.Батболд, "Нью Прогресс"-ын С.Бямбацогт, "ТБД" ХХК-ийн эзэн Д.Тэрбишдагва, "Бодь" группийн эзэн Л.Болд, "Бишрэлт"-ийн Б.Ундармаа, "Сод Монгол"-ын Ц.Анандбазар, "Ачлал трейд"-ийн М.Билэгт гээд чинээлэг гишүүдийн жагсаалт уртаас урт хөвөрнө. Өнгөрсөн жилийн улстөрчдийн ХОМ-тээ хамгийн их үнэт эдлэлтэй гишүүнээр тодорч байсан О.Содбилэг, ард иргэдээ тансаг хэмээн зад шүүмжилсэн "Дорнын говь" ХХК-ийн эзэн Б.Дэлгэрсайхан гишүүн ч энэ жагсаалтын урдуур эрэмбэлэгдэх нь гарцаагүй. Тэд унаа, утасны зардлаа татвар төлөгчдөөр даалгах "ядарсан" эрхмүүд биш. Хэтэрсэн энэ халамж байтугай, сарын цалингаасаа татгалзчихад нэг их гудайхааргүй хүмүүс гэдэг нь хэнд ч ойлгомжтой шүү. Сарын 1.542 сая төгрөгийн цалин тэдний хувьд магадгүй нэг оройн хоолны мөнгө биз. Өмнөд Солонгосын хүүхнүүд улс орныхоо эдийн засгийг аврахын тулд үсээ экспортолж, үнэт эдлэлээ хандивлаж байсан түүх бий. Үсээ экспортолж, үнэт эдлэлээ хандивладаггүй юмаа гэхэд, энэ мэт эрхэм гишүүд сарын цалин, халамжаасаа татгалзчихаж яагаад болохгүй гэж. Үнэхээр улс орныхоо төлөө төр түшилцэж яваа гишүүдэд бол сарын цалингаасаа татгалзах байтугай зүйлийг энэ үед хийх учиртай сан. Гэвч нэрт яруу найрагч Дөнгөтийн Цоодолын "Харамчийнхны дууль"-д дүрслэгдсэнтэй нэгэн адил тэд гараа үл тэнийлгэх аж. Зүдэрсэн иргэдийнхээ халаас руу өнгийх атлаа, өөрсдийн халаас руу орох мөнгөтэйгөө зууралдаж буй толгой баячуудыг "харамч" гэхээс өөрөөр юу гэж тодорхойлох билээ. Эцэст нь тэмдэглэхэд, УИХ-д байгаа "Харамчийнхан"-аас гуйх нэг хүсэлт байна. Эх орноо хямралаас гаргах хэмнэлт, хасалт, таналтаа өөрсдөөсөө эхлүүлж, ядарсан иргэддээ үлгэрлэвэл яасан юм.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
88873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ




## ЦЭНГЭЭНИЙ ГАЗРЫН ЦАГААР ОРОЛДОХООС ӨӨР ХИЙХ АЖИЛ АЛГА УУ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Манайхаас өөр улс оронд баар, цэнгээний газрууд нь 24 цагийн турш ажилладаг юм билээ. Мэдээж мань мэтийг бодвол хотын дарга гадаадын олон улс руу явж, галуу шувууны мах идсэн хүн тэр зэргийг мэддэг л байлгүй дээ. Гэтэл манайд яаж байна, бүх л зүйлийг хаана, хорино, цагдана. Дэлгүүр тэдэн цагт хаах ёстой, баар тэд хүртэл ажиллана гээд л. Манай улсад 24 цагийн дэлгүүр ч байхгүй. Буудал, зарим эмийн сан зэрэг тоотой хэдэн газар л 24 цагаар ажилладаг байх. Харин ашгүй хотын өмнөх удирдлагууд баар, цэнгээний газрыг 04:00 цаг хүртэл ажилладаг болгож, олон эерэг үр дагавартай шийдэл болгосон. Харамсалтай нь энэ шийдвэр одоогийн хотын даргын дургүйг хүргэжээ, янз нь. Баар, цэнгээний газар 04:00 цаг хүртэл ажилласнаар олон сөрөг зүйлийг бууруулсан. Ахуйн хүрээний архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, авлига хээл хахууль, шагийн архи гээд л. Энэ бүхэнтэй уялдаад маш олон эерэг хандлага гарч байсан. Зарим хүмүүс гэмт хэргийн тоо тэдэн хувиар буурсан. Тийм ч үзүүлэлт ингэж буурсан гээд янз бүрийн тоо бичээд байна. Тэрийг нь яг нарийн мэдэхгүй байна, хотын даргад бол олж мэдэхэд юухан байх вэ дээ. Тэр тоо баримтыг нь олж аваад, хараад эргэцүүлэн бодож шийднэ байгаа. Баар, цэнгээний газрын ажиллах цагийг 00:00 болгосноор сөрөг үр дагавар маш их гарна. Юуны өмнө ахуйн хүрээний архидалт нэмэгдэнэ. 00:00 цаг хүртэл баар саванд суучихаад, халуурсан нөхөд гэртээ харьж архидана. Эсвэл буудалд орно. Ингээд л зодоон цохион хийнэ. Цаашлаад гэмт хэрэг гарах нөхцөл бүрэлдэнэ. Гэртээ архидвал гэр бүлийн хүчирхийлэл, агсам согтуу тавих, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах байдал нэмэгдээд л явчихна. Хүссэн хүсээгүй нэмэгдэх үзүүлэлт. Бааранд бол яах вэ дээ, харуул хамгаалалттай учраас дураар нь зодолдуулаад байхгүй. Дээрээс нь цагдаа нарын халаасыг түнтийлгэх нэг арга бол баар, пабын ажиллах цагийг боомилох. Манайхан л болсон хойно хаалгаа түгжиж байгаад архи, шар айргаа зардаг. Хүмүүс ч энэ тэрүүгээр явж байхаар гээд гуйж байгаад л суудаг. Үүнийг нь цагдаа нар андахгүй шүү дээ.

...Архи шаглагчидтай тэмцэх гэж илүү ажил хийдгээ ч болио биз дээ, цагдаа нар. Гэх мэт давуу талууд маш олон байна. Энэ бүхнийг хотын дарга анзаарахгүй байгаа бололтой юм. Анзаарсан ч өмнөх удирдлагуудтай зөрж л байвал болоо гэсэн байдлаар хандаад байгаа юм биш биз дээ...

Эсвэл авлига авч, хэдэн төгрөг халааслаад ажиллуулдаг шүү дээ. Нөгөө талаар дэлгүүрүүдийг нь хорьж, цагддаг. Дээрээс нь баар, цэнгээний газрууд эрт хаахаар архи шагладаг нөхдүүд бороны дараах мөөг шиг л олширно биз дээ. Нэг хэсэг шагийн архи зардаг хүмүүс маш их байсан. Харин паб, цэнгээний газрууд 04:00 цаг хүртэл ажилладаг болсноос хойш шагийн архины наймаачид гэж байхгүй болсон. Архи шаглагчидтай тэмцэх гэж илүү ажил хийдгээ ч болио биз дээ, цагдаа нар. Гэх мэт давуу талууд маш олон байна. Энэ бүхнийг хотын дарга анзаарахгүй байгаа бололтой юм. Анзаарсан ч өмнөх удирдлагуудтай зөрж л байвал болоо гэсэн байдлаар хандаад байгаа юм биш биз дээ. Бусад улсуудад 24 цагаар баар, ресторан, дэлгүүр ажиллаж болоод байхад манайд л болохгүй байв гэж. Аливаа зүйлийг хорих, цагдах тусам гарах муу үр дагавар, далд бизнесүүд нэмэгддэг. Харин нээлттэй байх тусам муу үр дагавар нь багасдаг гэдэг нь угаасаа амьдрал дээр батлагдсан. Тийм болохоор хотын дарга баар, цэнгээний газрын цагийг наашлуулах асуудлаа дахин сайн судалсан дээр дээ. Үнэндээ хотод үүнээс өөр хийх ажил маш их байгааг ч анхаарчихад гэмгүй байх.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ







ММ-ИЙН ТОДРУУЛГА



## Д.ОЮУНХОРОЛ: Монгол, Кувейтын судалгааны төв үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна

*БОАЖ-ын сайд Д.Оюунхоролоос Монгол, Кувейтын судалгааны төвийн үйл ажиллагааны талаар тодруулллаа.*

**-Монгол, Кувейтын судалгааны төвийн үйл ажиллагаа өнөөдөр ямар байдалтай байна вэ?**

-Кувейт улсын санхүүжилтээр баригдсан Монгол, Кувейтын эрдэм шинжилгээний төвийн менежментийг “Монгол, Кувейтын судалгааны төв” ТББ гүйцэтгэж байна. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх Засгийн газрын тогтоол энэ оны нэгдүгээр сард гарч, тус ТББ-ын тэргүүнээр би сонгогдон ажиллаж эхэлсэн. Хоёр улсын Засгийн газар хоорондын “Харилцан ойлголцолын санамж бичиг”-ийн хүрээнд баригдсан уг эрдэм шинжилгээний төвийн барилгыг 2015 оны аравдугаар сард хүлээлгэн өгсөн байдаг. Гэвч ашиглалтын зардал нь шийдэгдэхгүй, дээр нь барилгын чанар маш муу, инженерийн шугам сүлжээний холболт хийгдээгүй зэргээс үүдэн зарим барилга нь эвдэрч, цуурч, мөөгөнцөртсөн байсан. ТББ байгуулагдаж, ашиглалт, менежментийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бүрдсэнээр одоогоор тус төвд байгаль орчны чиглэлээр хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулж байна. Цаашдаа аялал жуулчлал, байгаль орчны судалгаа, шинжилгээ хийдэг томоохон төв болгон хөгжүүлэх зорилго тавьж байгаа. Хэн ч гэсэн хардах эрхтэй юм болохоор эрдэм шинжилгээний төвийг хэн нэгэн хувьдаа авчихсан мэтээр буруу ташаа мэдээлэл цацагдсан. Тийм асуудал байхгүй. ТББ-ыг байгуулахад манай зарим эрдэмтэн, судлаачид ч оролцож, тусалж ирсэнд талархаж явдаг.

**-Уг төвийн барилгын өмчлөлийн асуудал хөндөгдөж байсан. Өнөөдөр яг хаанахын өмчлөлд байна вэ?**

-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна” гэсэн заалт байдаг. Энэ судалгааны төв дээр энэ хуулийн заалт хэрэгжиж байгаа. Цаашид харин өмчийн ашиглалтын асуудлыг төрд хариуцуулах чиглэлээр ажиллаж байна. Мөн энд ажиллаж байгаа хүмүүсээ цалинжуулах, урсгал зардлаа санхүүжүүлэх, Улаанбаатар хотоос зайтай оршдог зэргээс болоод багагүй хүндрэл бэрхшээл гардаг. Энэ бүх асуудлыг шийдвэрлээд үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд олон хүн хичээж зүтгэж байгаа. Хотоос алслагдмал уулын мухарт сэтгэлээрээ ажиллаж байгаа төвийнхөө ажилчдад талархаж явдгаа энэ дашрамд хэлмээр байна.

ЭДИЙН ЗАСАГ

ЭДИЙН ЗАСАГЧ ЯРЬЖ БАЙНА

# Н.ЭНХБАЯР: БИДЭНД ДОТООДЫНХОО НӨӨЦ БОЛОЛЦООГООР ЭДИЙН ЗАСГАА БОСГОХ БОЛОМЖ БАЙХГҮЙ

Н.ПУНЦАГБОЛД

*Эдийн засагч Н.Энхбаяртай эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн хэмнэлтийн асуудлаар ярилцлаа.*

> –Үнэхээр гадны ямар нэгэн байгууллагын дэмжлэггүйгээр хүндрэлээ даван туулах ёстой байсан бол бид аль хэдийнэ өнгөрсөн жил л хэрэгжүүлэх байсан юм–



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**-Төсөв хэмнэх талаар Засгийн газар дуугарч эхэлсэн. Монголбанк ч аль хэдийнэ бодлогоо хэрэгжүүлээд эхэллээ. Энэ тал дээр та юу хэлэх вэ?**

-Би түрүү жилүүдэд судлаачдын хийж байсан судалгааг саяхан эргэж харсан. Төсөв, мөнгөний бодлого хоёр маань харилцан бие биеэ нөхөж байх ёстой. Манай эдийн засагчид, их сургуулийн докторуудын хийсэн судалгаагаар 2009-2012 онд төсвийн тэлэх бодлогыг тодорхой хэмжээгээр явуулж байсан. Нөгөө талдаа мөнгөний хумих бодлого явуулж байсан судалгаа байна. Гэтэл 2012-2016 он хүртэл аль алийг нь тэлэх бодлого явсан, үндсэндээ. Одоо эргээд хумих тухай ярьж эхэлж байна. Уг нь тэлж байгаа бодлого маань тодорхой хугацааны дараа саарах ёстой байхгүй юу. Тогтворжилтын төвшинд хүрсэн нөхцөлд. Нөгөө талаар шингээх багтаамж гэж байна. Гэтэл тэр хязгаараа бид мэдрэхгүй явсаар байгаад өдийг хүргэсэн. Зөвхөн бүтээн байгуулалт, өсөлт гэж ярьсаар байгаад арга хэрэгсэл маань үр дүнгээ өгөхөө болиод, сөрөг хандлага руугаа ороод эхэлчихсэн. Тэгэхээр одоо гарцаа байхгүй хязгаарлах цаг болсон. Ялангуяа төсөв талдаа хязгаарлах бодлого явуулахаас өөр арга байхгүй. Харин цаг хугацааны хувьд энэ хоёр бодлого тодорхой нэгэн зэрэг явах ёстой юу. Эсвэл хугацааны хувьд зөрүүтэй байх ёстой юу гэдгийг Засгийн газар, Монголбанк хоёр ярих ёстой. Түрүүлээд Монголбанк бодлогынхоо хүүг нэмэхдээ Засгийн газар, Сангийн яамтай зөвлөсөн эсэхийг би мэдэхгүй байна. Монголбанкны хувьд яаралтай арга хэмжээ авах ёстой гэж бодлогынхоо зөвлөл дээр үзсэн байна шүү дээ. Нэгэнт ингэж хумих бодлого хэрэгжүүлж байгаа бол үргэлжлэх хугацаагаа сайн бодох хэрэгтэй. Ямар хугацаанд үргэлжлэх юм. Манай эдийн засагчид, эрдэмтэн судаалчид бол урт хугацаанд үргэлжлүүлэх ёсгүй. Аль болох богино хугацаанд хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байгаа. Тэгээд дээрээс нь төсвийнхөө бодлоготой уялдуулах шаардлагатай гэж үзэж буйгаа илэрхийлсэн. Тийм болохоор энэ нэлээд төвөгтэй асуудал. Хоёрдугаарт, бодлогын үр дүн маань амьдралаас тасалж аваад хийчихсэн судалгаа биш байхгүй юу. Мөнгөний бодлого дангаараа үр дүнд хүрэхгүй. Үүнтэй хамт гадаад бодлого, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчин гээд бүх бодлогын нөлөөлөл чинь зэрэг явж байгаа учраас барилга байшин барьж байгаа юм шиг л шууд олон нийтэд үр дүн нь харагдахгүй.

**-Монголбанк мөнгөний бодлогын хүүгээ нэмсэн нь төсөвтэйгээ зөрчилдсөн гэж үзэж болохоор байгаа. Одоо төсвийн тодотгол хэлэлцэж байна. Энэ асуудлыг цэгцлэх болов уу, та юу гэж харж байна?**

-Монголбанкны бодлогын арга хэмжээ авсан үндэслэл нь нөхцөл байдалтай холбоотой гэж байгаа. Гэхдээ нөхцөл байдал маань өөрөө ганцхан төсвийн алдагдал биш байхгүй юу. Валютын орлого хомсодчихсон, дээрээс нь ханшийн савлагаатай байна. Гэх мэт олон үзүүлэлт байгаа учраас энэ арга хэмжээг авч байгаа юм. Магадгүй энэ бодлогын эхний үр дүн оны эцэст харагдаж эхлэх байх. Мэдээж тодорхой хугацаа шаардагдана. Харин одоо төсвийн бодлого ярихдаа ямар хугацаанд энэ хоёр бодлогыг хэрэгжүүлэх юм бэ гэдгээ л шийдэх ёстой.

> ...Яг тэр арга хэмжээнүүд өнөөдөр хэрэгтэй байгаа юм. Харамсалтай нь тэр арга хэмжээнүүд гуравдугаар сараас хойш огт хэрэгжээгүй. Эвсч байсан Засгийн газар хоёр тийшээ болсон. Дараа нь сонгуулийн зорилгодоо автсан. Энэ бүх байдлаас болоод тухайн үед дотооддоо авч болох бүх арга хэмжээгээ аваагүй байхгүй юу. Тийм учраас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрчихээд байгаа юм...

**-"Стэнд бай" хөтөлбөрт хамрагдах талаар яригдаад байгаа. Энэ хөтөлбөрт үнэхээр хамрагдах шаардлагатай юу?**

-Манай судлаачид олон улсын байгууллагын янз бүрийн арга хэрэгсэл байгаа талаар ярьж байна. Зөвхөн ганц Олон улсын валютын сангаас Олон улсын банк санхүүгийн байгууллагууд бүгдээрээ тухайн улс орны нөхцөл байдлаас хамаараад олон төрлийн зээлийн дэмжлэг үзүүлж байна. Энэ талаар манай эдийн засагч, докторууд хангалттай ярьж, сануулж байгаа. Яах вэ, бидний өмнө хэрэглэж байсан арга нь "Стэнд бай" болохоор энэ талаар яриад байгаа байхгүй юу. "Стэнд бай" хөтөлбөрийн онцлог нь нэгдүгээрт, богино хугацааных. 12-18 сарын хугацаатай л байдаг. Маш богино хугацааных. Бид 2008-2009 онд энэ хөтөлбөрийг авч, хэрэгжүүлсэн. Зорилго нь богино хугацааны төсвийн болон төлбөрийн тэнцлийн алдагдлыг нөхөхөд зориулсан хөтөлбөр юм. Хэрвээ Монголбанк, Засгийн газраас Олон улсын валютын сан, Олон улсын байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай гэж үзвэл аль аль талаасаа ажлын хэсэг гаргаж, уулзаж ярилцана. Аль аль талынхаа нөхцөл, шаардлагыг биелүүлсэн нөхцөлд л энэ хөтөлбөр хэрэгжинэ. Мөн манай Засгийн газар, Монголбанк хөтөлбөрт хамрагдая гэж зөвшөөрсөн нөхцөлд Олон улсын валютын сан захирлынхаа зөвлөлийн хурлаар хэлэлцэж байж эцсийн хариу гардаг. Тодорхой санхүүгийн дэмжлэг хамт байгаа учраас тэр мөнгийг нь захирлуудын зөвлөл шийддэг. Ийм л процесстой.

**-Төсвийн хэмнэлт хийнэ гээд л байгаа. Хэмнэлт хийлээ гээд үр дүн гарах уу?**

-Ямар ямар зардал хасаад, хэчнээн төгрөг хэмнэхийг Сангийн яамны нөхдүүд л хэлнэ шүү дээ. Хамгийн гол асуудал нь хэмнэлт хийлээ гээд зогсохоор хэмжээнд биш, илүү гүнзгийрчихсэн байхгүй юу. 2012 оноос хойш бүтэн дөрвөн жил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Хөгжлийн банкаар, ипотекийн зээл гээд маш олон сувгаар эдийн засаг руу их хэмжээний мөнгөний нийлүүлэлт хийчихсэн. Тийм болохоор зөвхөн төсвийн зарлагаар шийдэгдэхгүй. Маш хүндрэлтэй болчихсон. Дээрээс нь төсвөө баталж байгаа тогтолцоо маань хуучин хэвээрээ байна. Энэ оны тухайд яах вэ, хасдаг юм байж. Харин ирэх оны төсөвт дахиад л бодит байдлаасаа илүү хөөрөгдчихсөн, өөдрөгөөр төлөвлөчихсөн төсөв гарч ирэх магадлал маш өндөр байгаа. Таналт гэдэг бол зөвхөн тодотголын тухайд л ярьж болох зүйл. Харин ирэх оны боловсруулж байгаа төсөв дээр тогтолцооны гажуудлаа засах тухай ярих ёстой байхгүй юу. Тэгж байж макро эдийн засгийн тогтворжилт бий болно. Төсөв мөнгөний бодлогын залруулах гээд байгаа эхний үр дүн нь макро эдийн засгийн тогтворжилт байхгүй юу. Түүнээс биш төсвийг заавал алдагдалгүй байлгаж, тэнцлийг нь барих гээд байгаа юм биш. Төсөв мөнгөний бодлогоос эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллөө тогтворжуулж байж макро эдийн засгийн үзүүлэлт нь тогтворжино. Ингээд ирэхээр гадаадын хөрөнгө оруулалт, бизнест таатай орчин бүрдэх юм. Ийм л зорилготой.

**-Монголбанк мөнгөний бодлогын хүүгээ нэмээд, Засгийн газар хэмнэх бодлого бариад эхлэхээр эдийн засаг хэцүүдэх юм биш үү?**

-Монголбанк бол шийдвэрээ гаргачихсан. Засгийн газар хараахан шийдвэрээ гаргаагүй байна. Хумих шаардлагатай байна гэж л яриад байгаа. Хумихыг эцсийн байдлаар УИХ дээр төсөв баталж байж шийднэ. Төсвийн хуультай хамт бодлого нь батлагдана. Үүнийг ярих үед зайлшгүй Монголбанктай УИХ зөвлөлдөж таарна. Энэ хоёр хумих бодлогыг зэрэг явуулах уу, үгүй юу гэдгийг ирэх оны төсөв хэлэлцэх үед зайлшгүй ярих ёстой байхгүй юу. Тэгж байж зохистой харьцааг нь барина. Түүнээс биш аль алийг нь хумиж болохгүй. Дээрээс нь үргэлжлэх хугацаа өөр. Төсвийн бодлого бол оны эхэнд батлаад, бүтэн жил үргэлжилдэг шүү дээ. Харин Монголбанк бол өөрөө бие даасан байгууллага учраас бодлогын зөвлөлөөрөө шаардлагатай үед хатуу бодлогоо зогсоох боломжтой. Цаг үеийнхээ шаардлагын дагуу буцаагаад бууруулж болно.

**-Бидэнд гадаадын ямар нэг хөтөлбөрт хамрагдахгүйгээр өөрсдөө эдийн засгаа босгох гарц огт байхгүй юм уу. Энэ талаар их бага яриад байх шиг?**

-Ярихын хувьд ярьсан. 2015 оны нэгдүгээр сард УИХ-аас гарсан тогтоол байгаа. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах тухай хөтөлбөр гэж байна. Тэр хөтөлбөрийн дараа гуравдугаар сард Засгийн газраас 200 гаруй заалттай арга хэмжээний хөтөлбөр гарсан байгаа. Одоо тэр тухай нэг их ярихгүй байгаа болохоор бараг мартчихсан юм шиг байна, хүмүүс. Яг тэр арга хэмжээнүүд өнөөдөр хэрэгтэй байгаа юм. Харамсалтай нь тэр арга хэмжээнүүд гуравдугаар сараас хойш огт хэрэгжээгүй. Эвсч байсан Засгийн газар хоёр тийшээ болсон. Дараа нь сонгуулийн зорилгодоо автсан. Энэ бүх байдлаас болоод тухайн үед дотооддоо авч болох бүх арга хэмжээгээ аваагүй байхгүй юу. Тийм учраас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрчихээд байгаа юм. Үнэхээр гадны ямар нэгэн байгууллагын дэмжлэггүйгээр хүндрэлээ даван туулах ёстой байсан бол бид аль хэдийнэ өнгөрсөн жил л хэрэгжүүлэх байсан юм. Гэтэл цаг хугацаа алдчихсан. Өнгөрсөн жил валютын нөөц, төсвийн алдагдал маань ч гайгүй байсан. Тийм байхад бид боломжоо алдчихсан. Тэгэхээр одоо дотоодынхоо нөөц бололцоогоороо эдийн засгаа босгох боломж байхгүй гэж хэлж болно. Тийм болохоор богино хугацааны гадны санхүүгийн дэмжлэг зайлшгүй хэрэгтэй болчихоод байна. Дээрээс нь гадаад төлбөрийн хугацаа хэдхэн сарын дараа боллоо. 2017 оны нэгдүгээр сарын 1-нээс төлж эхэлнэ.

**-Гадаадтөлбөрийнхугацаа хаяанд ирчихлээ. Энэ өрийг хугацаанд нь төлж чадахгүй байх магадлал өндөр гэж судлаачид яриад байгаа. Манайд ямар гарц байгаа юм бол?**

-Түрүүний бидний ярьсан зүйл бол манай улсын дотоод макро эдийн засгийн асуудал. Өр бол арай өөр асуудал. 2012 онд бид гадаад бонд гаргахдаа Засгийн газрын танилцуулга хийсэн. Мөнгө татахын тулд шүү дээ. Үнэт цаасны хөрөнгийн бирж дээр очоод, Монголын эдийн засаг ийм сайн үзүүлэлтэй, ингэж тэлж байна. Худалдааны эргэлт ийм байгаа. Дээрээс ийм ийм том төслүүд хэрэгжинэ. Гэх мэт сайхан мэдээллийг хийж байгаад бондын мөнгийг босгосон. Харин бонд худалдаж аваад, бидэнд мөнгөө зээлүүлсэн хөрөнгө оруулагчид Монголын эдийн засаг цаашид тогтвортой өсөөд явна. Том төслүүд нь эргэлтэд орох юм байна. Тэндээсээ бидний мөнгийг өгөх юм байна гэсэн итгэлээр зээл өгчихсөн. Гэтэл хийж байсан танилцуулгаасаа нөхцөл байдал 100 хувь эргэчихсэн. Манай том төслүүдээс ганцхан Оюу толгой л хөдөлж байна шүү дээ. Бусад бүх том төслүүд нь урагшаа ахиагүй. Дэд бүтэц нь байхгүй. Бид их сайхан, гэрэлтэй эдийн засгийн өсөлт рүү явна гэж бонд босгочихоод цагаа тулахаар "Уучлаарай, одоо бид төлж чадахгүй нь" гэж хэлэх байдал руу л орох гээд байна шүү дээ. Тэгэхээр одоо бондынхоо бүтцийн өөрчлөлтийг хийх. Өөр бага хүүтэй, урт хугацааны бондоор орлуулах л ёстой гэж манай судлаачид үзэж байгаа. Эхний ээлжинд ийм л арга хэмжээ авна.

**-Энэ чинь өөр нэг зээлээр одоо байгаагаа дарж байгаагаас ялгаа байна уу. Иргэд бол ингэж л ойлгоно. Та арай ойлгомжтой байдлаар тайлбарлаад өгөх үү?**

-Зээл бол биш. Бага хүүтэй, урт хугацааны бондоо нөхөн төлнө гэсэн үг. Адилхан л төлөх мөнгө болов ч арай бага хүүтэй, урт хугацаатай болгоод хугацааг нь сунгачихлаа л гэсэн үг. Бондын нэг ялгаатай тал нь цувруулж төлдөггүй. Үндсэн төлбөрийг төлөх ёстой эцсийн өдөр гэж байна. Тэр өдрөө л багтааж төлөх ёстой. Хэрвээ төлж чадахгүй бол Олон улсын зах зээл дээр дефолт буюу дампуурал зарлачихаж байгаа юм. Тиймээс төлөх ёстой өдрийг л хойш нь сунгах гээд байгаа хэрэг.

**-Орлуулах бондыг нь юу гэж харж байна?**

-Зайлшгүй Олон улсын банк санхүүгийн байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжинэ. Би саяхан Мексикийн жишээг нэг хурал дээр танилцуулсан. Мексик 1990-ээд оны дундуур хүнд байдалд орсон. Ер нь Латин Америкийн олон орон хүнд байдалд орсон. Тэр дундаас хүндрэлээ хамгийн амжилттай давсан нь Мексик байхгүй юу. Мексик улс АНУ-ын валютын сантай хэлцэл хийгээд, төлөх хугацаа нь тулчихсан бондоо Америкийн төрийн сангийн 30 жилийн хугацаатай Засгийн газрын бондоор сольчихсон байхгүй юу. Тэгэхээр Мексикийн Засгийн газар төлбөрөө бонд эзэмшигчдэд биш АНУ-ын Засгийн газарт төлөх ёстой болчихож байгаа юм. Гэхдээ 30 жилийн хугацаатай. Ийм хөрвүүлэг хийж чадсан. Тэгээд 2003 он гэхэд тэр бондоо төлөөд дуусгачихсан. Ийм амжилттай болсон жишээ байгаа.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

# ОНЦЛОХ ХУУДАС

# ТАТВАР НЭМЭХ НЬ ЗӨВ, БУРУУ

## Эсрэг тэсрэг байр суурь

### Ч.Хүрэлбаатар: Татвар нэмэхийг дэмжихгүй



...Манай орны валютын нөөц хомс байна. Ийм нөхцөлд бид ямар бодлого явуулах вэ гэдгээ олон талаас нь авч үзэх ёстой. Эдийн засаг өсч, тэлж байгаа үед татвар нэмэхэд ямар ч асуудал байхгүй. Учир нь эдийн засгийн хэт халалт бий болохоос сэргийлж татвар нэмэх арга хэмжээг авдаг...

*/УИХ-ын гишүүн/*

-Өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдал ямар байгаа вэ гэдгийг хэн хэнгүй мэдэж байгаа. Хоёр жилийн өмнө эдийн засгийн асуудлыг бид ярьдаг байсан. Монгол Улсын эдийн засаг агшиж байна. Үүний зэрэгцээ улсын төсөв бүрдэхгүй байна. Манай орны валютын нөөц хомс байна. Ийм нөхцөлд бид ямар бодлого явуулах вэ гэдгээ олон талаас нь авч үзэх ёстой. Эдийн засаг өсч, тэлж байгаа үед татвар нэмэхэд ямар ч асуудал байхгүй. Учир нь эдийн засгийн хэт халалт бий болохоос сэргийлж татвар нэмэх арга хэмжээг авдаг. Харин эдийн засаг хумигдаад, унаж яваа энэ үед хөрөнгө оруулагчид хүнд байдалтай байгаа нь үнэн. Энэ мэтчилэн иргэдийн орлого буурчихсан нөхцөлд татвар нэмнэ гэдэг нь цаашид эдийн засгийн агшилтыг хурдасгах эрсдэлтэй. Тиймээс татвар нэмэх энэ асуудлыг дэмжих боломжгүй. Тэр утгаараа Төсвийн байнгын хорооны хуралдаан дээр татвар нэмэх хуулиудыг хойшлуулбал яасан юм бэ гэдэг санал гаргасан. Нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэх асуудал төсвийн тодотголд байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэлэлцэх явцад бид ярина. Одоо Монгол Улсад төлж буй Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ бусад орнуудтай харьцуулахад өндөр. Бусад орноос өндөр байхад нь дахиад нэмнэ гэж байгаа бол үндсэндээ хувийн хэвшлийнхэн ажиллагсдынхаа цалинг бууруулах, худлаа тайлан гаргах зэрэг бидний өнгөрсөн хугацаанд засч залруулахаар хичээж байсан бүх ажилд ухралт гарна. Тиймээс одоогийн түвшинд хангалттай өндөр байгаа шимтгэлийг нэмэгдүүлэх нь далд эдийн засгийг бий болгох эрсдэлийг үүсгэнэ.Түүнчлэн 150 метр квадратаас дээш орон сууцны татварыг нэмэх асуудлыг судлах шаардлагатай. Өндөр орлоготой иргэд энэ байранд байгаа тохиолдолд татвар авах нь буруу биш гэж бодож байгаа.

### Ц.Даваасүрэн: Гэртээ хоносныхоо төлөө яагаад татвар төлнө гэж...

*/УИХ-ын гишүүн/*

-Төсвийн тодотголоор дундаж орлоготой иргэд рүү нэлээд халдаж байна. Гэр бүлээ авч яваа, боломжийн орлоготой болохоор тэмүүлж байгаа хэсгийг нам цохиод хаячихаж байна. Түүгээр ч барахгүй том талбайтай орон сууцанд амьдардаг байлаа гээд гэртээ хоносныхоо төлөө яагаад татвар төлж байгаа юм. Эдийн засгийн хямралтай үед татвар нэмэх бус татварын бодлогоороо ажлын байр нэмж, татвар төлөгчийнхөө тоог нэмэгдүүлэх бодлого баримталбал хямралаас гарна. Энэ чиглэл рүү бодлого явсан бол хямралын ард гарах байсан байх. Түүнээс одоо иргэд хийж байгаа бизнесээ жаахан өргөн болгох гэхээр орлогоо нуух байдал руу орох болчихоод байна. Орон сууцны татварын тухайд 365 хоногт хуваахаар өдөрт 30 мянган төгрөг боллоо гэж бодъё. Тэгэхээр ийм айлууд бараг гэртээ хоноод 30 мянган төгрөгийн татвар төлж байхаар хямдхан зочид буудалд хоночихсон нь дээр болоод байна. Тухайн хүн орон сууцаа түрээсэлж орлого олоогүй, байгаль орчинд хохирол учруулаагүй, гэртээ хоносныхоо төлөө яагаад татвар төлөх гээд байгаа юм.

### Д.Хаянхярваа: Өндөр орлого бүхий иргэдийн татварыг л нэмж байгаа



...Төсөвт өртөг нь нэмэгдсэн объектын нэмэгдсэн хөрөнгийг нь олгохгүй байхаар, санхүүжилт нь хэтэрсэн төслүүдийн нэмэгдсэн хөрөнгийг шинээр олгохгүй байхаар, шинээр нэмэгдсэн объектуудын хөрөнгийг төсвийн хөрөнгө оруулалтаас хасахаар шийдсэн...

*/УИХ дахь МАН-ын бүлгийн дарга/*

-МАН-ыг бүлгээс өнөөдрийн /өнгөрсөн баасан гарагийн/ хурлаар төсвийн тодотголд тусгасан архи, тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Мөн хос хөдөлгүүрт автомашины албан татварыг нэмэгдүүлэхгүй байхаар шийдлээ. Үүнээс гадна нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг төсвийн тодотголоор хэлэлцэхгүй байхаар тохиролцсон. Харин улсын төсвөөс болон төсвийн хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх төсөл арга хэмжээг дотор нь хоёр ангилан авч үзсэн байна. Төсөвт өртөг нь нэмэгдсэн объектын нэмэгдсэн хөрөнгийг нь олгохгүй байхаар, санхүүжилт нь хэтэрсэн төслүүдийн нэмэгдсэн хөрөнгийг шинээр олгохгүй байхаар, шинээр нэмэгдсэн объектуудын хөрөнгийг төсвийн хөрөнгө оруулалтаас хасахаар шийдсэн. Хүн амын орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын саналыг хэвээр үлдээгээд байна. Мөн НДШ-ийг нэмэхгүй байхаар шийдсэн. Хүн амын орлогын албан татварын хувьд нийгэм тэр чигээрээ хүн амын орлогын албан татварыг нэмчихлээ гэж ойлгож байна. Бид өндөр орлого бүхий иргэдийн татварыг л нэмж байгаа. Өөрөөр хэлбэл 2,5 сая төгрөгийн орлоготой хүний татварыг нэмж байна. Харин 150 мкв орон сууцтай иргэдээс татвар авах тухай бол ногдуулна. Тухайлбал, 200 мкв орон сууцтай иргэн хүнд татвар ногдуулахдаа 150 мкв-ыг хасаад 50 мкв татвар оногдуулна. Энэ бол дэлхий нийтэд баримталдаг зарчим.

### Б.Чойжилсүрэн: Иргэд, компаниуд хүнд байгааг ойлгож байна, гэхдээ...

*/УИХ-ын гишүүн, Сангийн сайд/*

-МАН мөрийн хөтөлбөрөөсөө ухраагүй ээ. Манай мөрийн хөтөлбөрт байгаа шүү дээ. Эдийн засгийн уналтыг зогсоож, эргэн сэргээнэ гэж. Энэ мөчлөгийг хоёр хувааж байгааг би хэлсэн. Одоогийн эдийн засаг ямар байгааг ойлгуулах гэж дахин дахин яриад байгаа. Хувь хүний орлогын албан татварт өөрчлөлт оруулалаа гэхэд тэнд 400 мянган хүн хамрагдахгүй. Нийгмийн даатгалын шимтгэл төлдөг 900 мянга орчим хүн байгаагаас 1.6 хувь нь буюу 14 мянган хүн татварын өөрчлөлтөд хамрагдах юм. Арван жилийн өмнөөс бид 4/10-ын татварын бодлого баримталж ирсэн. Экспортын бүтээгдэхүүний үнэ өндөр байх үед 10 хувийн татвар авч болоод байдаг байжээ. Эдийн засгийн хүндрэлтэй үед 10 хувийн татвар авахаар төсвийн орлого бүрдэхгүй байна шүү дээ. Улсын нэгдсэн төсөв 5.3 их наяд төгрөгийн орлоготой, 9.7 их наяд төгрөгийн зарлагатай, 4.4 их наяд төгрөгийн төсвийн алдагдалтай. Ийм нөхцөл байдал л биднийг угтаж авсан. Аль нэг улс төрийн хүчин хэзээ нэгэн цагт төсвийн алдагдлаа нөхөхийн тулд ийм арга хэмжээ авах л байсан. Эсвэл энэ чигээрээ санхүүгийн сахилга батгүй байдлыг үргэлжлүүлж, энэ улсаа дампууруулах юм уу. Монгол Улс онц хүнд байдалд орчихоод байна. Алтны зах зээл далд хэлбэр рүү орохыг үгүйсгэхгүй, гэхдээ ингэж айхгүйгээр орлогоо нэмэгдүүлж, зарлагаа бууруулаад төсвийн орлогоо тэнцвэржүүлмээр байна. Алтны татвар 2.5 хувь болсноор алт тушаалт тодорхой хувиар нэмэгдсэн. Алтны татварыг таван хувь болгосноор 20 орчим тэрбум төгрөг цуглуулахаар төлөвлөсөн. Татвар нэмснээр орлого нэмэгдэнэ. Засгийн газар, Сангийн яам менежментээ сайжруулж ажиллана. Орон сууцны татварын хувь 150 ам.метртэй байрнаас авна. Энэ бол дэлхийн жишигт байдаг тансаг хэрэглээний татварын төрөл. Түүнчлэн онцгой албан татварын асуудал дээр жилийн орлого нь 30 сая төгрөг буюу сарын орлого нь 2.5 сая төгрөгөөс дээш цалинтай хүмүүсээс 25 хувийн татвар авна. Сарын орлого нь 2.5 сая төгрөгөөс бага иргэд 10 хувиараа татвараа төлөөд явна. Зарим гишүүд татварын хэмжээг огцом буулгах хэрэгтэй гэж байна. Зарим нь орлогоо бууруулаад, зарлагаа нэмлээ гэж шүүмжилдэг. Архи, тамхины татварыг 20 хувиар нэмэгдүүлэхээр ярьж байна. Иргэд, компаниуд хүнд байгааг ойлгож байна. Гэхдээ энэ мэтчилэн арга хэмжээнүүд авч, төсвийн орлогоо нэмэгдүүлэхгүй бол нийт улсаараа дампуурах нь байна шүү дээ. Эдийн засгийг сэргээнэ гэж МАН-ын мөрийн хөтөлбөрт багтсан. Эдийн засгаа тогтворжуулахын тулд зайлшгүй эдгээр арга хэмжээг авах шаардлагатай болоод байна. Бидний мөрийн хөтөлбөрөө боловсруулж байх үеийнхээс эдийн засаг илүү хүндэрсэн байна.

## Сэтгүүлчийн дүгнэлт

### ИНГЭЭД БАЙВАЛ АРД ТҮМЭН “ЭЛЭГДЭЭД” УНАГАХ БАЙХ ДАА

Ж.ОТГОН

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Төсвийн тодотголыг хэлэлцэж байгаа. Энэ хүрээнд МАН-ын Засгийн газар татвар нэмэх асуудлыг ч ярьж эхлээд байгаа юм. Тиймээс МАН мөрийн хөтөлбөрөөсөө ухарсан зүйлсийг оруулж ирлээ, эдийн засаг ийм хүнд байгаа үед татвар нэмэх асуудал оруулж ирж байгаа нь буруу хэмээн бухимдах хүн парламентын танхимд олон байна. Тиймээс ч Сангийн сайд болоод УИХ-ын гишүүд татвар нэмэхийг дэмжинэ, дэмжихгүй гэх зөрүүтэй мэдээлэл өгсөөр байна. Энэ удаагийн тодотгол татварт дөрөөлсөн төсвийн тодотгол болсон. Өөрөөр хэлбэл, иргэд оршин суугаа байшин, авдаг цалингаасаа хамаарч татвар төлөхөөр болоод байна. Тодруулбал, 2.5 сая төгрөгөөс дээш цалинтай иргэд, 150 ам.метрээс дээш талбайтай орон сууцтай өрх давхар татвар төлөх, оюутны тэтгэлгийг зогсоох, хүүхдүүдийн 60 хувьд нь 20 мянган төгрөг олгох гэх мэтээр асуудлыг яриад буй. Мөн архи, тамхи, дарсанд ногдуулах онцгой албан татварыг ч нэмэхээр болж байна. Энэ нь нэг талаар элгээрээ хэвтээд байгаа эдийн засгаа босгох гэж байгаа мэт боловч нөгөө талаар хуулийн дагуу иргэдээ “дээрэмдэх” төлөвлөгөө гэж харагдаж байгаа юм. Хэдхэн хоногийн өмнө “төрийн өндөр албан тушаалтнуудын буюу өөрсдийнхөө цалинг 10-30 хувь бууруулахаар боллоо” хэмээн сүржин мэдэгдэл хийгээд байсан ч харамсалтай нь угийн “халаас нимгэн” гишүүд маань цалингаасаа хасуулахыг хүссэнгүй. Тиймээс оронд нь татвараар дарамталж, “хуульчлагдсан дээрэм” хийхээр нэгэнт эргэлт буцалтгүй шийдсэн гэдэг нь илт.

Иргэдийг санхүүгээр нь “элэгдээд унагах” өөр нэг “дээрэм” нь тэтгэвэрт гарч байгаа албан хаагчдад олгодог тэтгэмжийг 36 хүртэл сар байсныг 12 сар болгон бууруулж байгаа юм. Тухайлбал, Авлигатай тэмцэх газарт 10-аас доошгүй жил ажилласан албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол түүнд албан тушаалынх нь 36 сар хүртэл цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгодог байсан. Харин одоо үүнийг 12 сар хүртэл болгохоор Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулж байна. Тэртэй тэргүй эдийн засаг хямарчихсан, хүн ам орлогогүй, дийлэнх нь цалин, тэтгэврийн гээд зээлтэй болчихсон байгаа энэ үед эмзэг хэсэг рүү очиж байгаа мөнгийг багасгах юм бол ядуурал улам бүр нэмэгдэнэ гэдгийг тэнэг биш л бол мэдэх ёстой баймаар юм. Тиймээс хэдхэн сарын өмнө сонгогдсон тойрогтоо очиж “амаа цангатал амлалт” өгч байснаа санаж, эрхэм гишүүд иргэдийнхээ бүсийг чангалахгүйгээр өөрсдийнхөө тансаглалыг хязгаарласан тодотгол хийх хэрэгтэй болоод байна.

Ганцхан жишээ дурьдахад, албан тушаалтнуудын шатахуун, утасны хэрэглээ болон тавилгын зардлыг 30 хувиар бууруулахаар төлөвлөж байгаа. Зөвхөн утасны хэрэглээг 30 хувиар бууруулахад жилдээ 100-200 сая төгрөг хэмнэх боломжтой гэх мэдээллийг Сангийн яамнаас өгсөн. Түүнчлэн гишүүдийн сарын утасны төлбөр гэж 100 гаруй мянган төгрөг, унааны зардалд 300 гаруй мянган төгрөг зарцуулж байгаа. Албан тушаалын бэлэг гэх дэд сайдуудын суудал гээд үр ашиггүй хэт өндөр зарлагаа танах талаар толгойгоо чилээвэл яаж байна. Хэрвээ МАН олонхиороо зүтгүүлээд хуулиа баталчихвал, “Бид зүтгэнэ-Хамтдаа хөгжинө” хэмээн Монгол Улсын иргэн бүрт “молиг үмхүүлсэн” амлалт талаар болох нь. Тэд энэ удаад бүр иргэн бүрт амлалт өгсөн шүү. Тухайлбал, цалинтай ээж, төлбөрийн дарамтгүй оюутан, ахмадаа ачилна, аз жаргалтай гэр бүл гэх алт шиг амлалтаа нэг санаач. Ард түмэн тэнэг биш. Тиймээс хэдхэн хоногийн дараа болох орон нутгийн болон Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчид МАН-д ямар дүн тавих нь тодорхой биз. Тэгээд ч иймэрхүү үйлдлээ гаргаад байвал ард түмэн “элэгдээд” унагахаа мэдэх байлгүй дээ.

# ДЭЛХИЙ



# “Их 20”-ийн ЭРГЭН ТОЙРОНД

Б.ДАВААХҮҮ

Хятадын зүүн этгээдийн Ханзоу мужид их 20-ын уулзалт зохион байгуулагдаж, өчигдөр албан ёсоор өндөрлөлөө. “Их 20”-ийн бүлгийг “Аж үйлдвэржсэн болон хөгжиж буй улсуудын” гэж тодотгодог. Эдгээр 20 орны удирдагчид Хятад улсад уулзаж, дэлхийн эдийн засагт тулгарч байгаа сорилтуудыг хэлэлцлээ. Уулзалтад ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, ХБНГУ-ын Канцлер Ангела Меркель, Японы Ерөнхий сайд Шинзо Абэ, АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама болон БНХАУ-ын дарга Си Зиньпин тэргүүтэй удирдагчид оролцсон бөгөөд дэлхийн эдийн засгаа тогтвортой өсгөхийн тулд улс орнууд хэрхэн хамтран ажиллах тухай асуудал дээд хэмжээний уулзалтын гол сэдэв байв. Үүнээс гадна олон удирдагч нэг дор цугларснаа ашиглаж хоёр талын уулзалтуудыг хийсэн. Тиймээс Их 20-ын эргэн тойрон дахь сонирхол татсан хоёр талт уулзалтуудын талаарх мэдээллийг хүргэе.

## Хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг уриалав

Хятадын дарга Си Зиньпин Их 20 уулзалтын хүрээнд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтай уулзлаа. Энэ үеэр Си дарга “Хятад, ОХУ бүх чиглэлт стратегийн хамтын ажиллагаагаа өргөжүүлж, бүрэн эрхт, аюулгүй байдлаа бэхжүүлэн, эрх ашгаа хамгаалан, харилцан нэг нэгийгээ дэмжих” хэрэгтэйг энэ үеэр онцолжээ. Тэрбээр энэ үгээрээ өмнөд Хятадын тэнгис дэх Хятадын байр суурийг дэмжихийг ОХУ-д уриалсан хэмээн зарим эх сурвалж онцолж байна. Хоёр улс энэ сард Өмнөд Хятадын тэнгист хамтарсан цэргийн сургуулилт хийхээр төлөвлөсөн. Сургуулилт нь тус бүс нутагт цэргийн ажиллагаагаа идэвхжүүлж байгааг шүүмжилж буй АНУ гэх мэт барууныхныг эсэргүүцэх нэг хэлбэр болж байгаа юм. Гэхдээ ОХУ албан ёсны мэдэгдэлдээ, Өмнөд Хятадын тэнгис дэх хилийн цэстэй холбоотой асуудлаар сөргөлдөгч талуудын аль нэг талыг баримтлахгүй. Төвийг сахисан байр сууринаас хандана гэдгээ мэдэгдээд байгаа. Мөн уулзалтын үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч амлалтаа биелүүлж, Си Зиньпинд зайрмаг бэлэглэжээ. Тэрбээр “Амласан ёсоор нэг хайрцаг зайрмаг авчирсан” хэмээн бэлгээ өгсөн бол Си дарга сайхан сэтгэлд нь талархал илэрхийлсэн байна.

## Барак Обамаг үл хүндэтгэв

Хятадын Ханзоу мужид зохион байгуулагдсан Их 20-ын бүлгийн уулзалтад оролцохоор АНУ-ын төрийн тэргүүн энэ сарын 3-нд тус улсад хүрэлцэн очжээ. Б.Обамагийн хувьд Ерөнхийлөгчийн албыг хашиж байх хугацаандаа оролцож буй сүүлийн дээд хэмжээний уулзалт болсон. Гэвч түүнийг Хятадад газардах үед үл хүндэтгэсэн том алдаа гарсан гэнэ. Уг нь түүнийг улаан хивсээр бүрсэн хүндэтгэлийн шатаар буулгаж авах ёстой байсан ч тэр нь байгаагүй аж. Тиймээс онгоцны сүүл хэсэгт очиж онгоцны өөрийн шатаар буухаас аргагүйд хүрсэн байна. Б.Обамаг гарч ирсний дараа хамгаалалтын ажилтнууд нисэх буудалд цугларсан сэтгүүлчид, тэр дотор АНУ-ын Цагаан ордны сэтгүүлчийг хүчээр холдуулж, цэнхэр олс татан дотогш нэвтрүүлэхийг хүсээгүй байна. Үүнээс болж олон сэтгүүлч Б.Обамагийн албаны хүмүүстэй гар барьж байгаа агшныг гэрэл зураг, видео бичлэгт буулгаж чадаагүй аж.

Америкийн тал энэ талаар гомдол гаргатал “Энэ бол манай улс, манай нисэх онгоцны буудал” хэмээн уурласан гэнэ. Тэгвэл энэ явдал эдүгээ америкчуудын гайхшлыг төрүүлээд байна. АНУ-ын томоохон хэвлэл хийгээд ажиглагчид уг явдлыг зүгээр ч нэг алдаа гэж үзэхгүй байгаа юм. БНХАУ-ын тал Их 20-ийн чуулганд ирсэн ОХУ, Их Британи, Энэтхэг, Бразиль гээд бүх улсын төрийн тэргүүнийг улаан хивс дэлгэн угтсан байна. “Дэлхийн хамгийн онцгой онгоц “Air Force One”-ийг үл анзаарч, АНУ-ын Ерөнхийлөгчид улаан хивс дэвссэн шатаа тавьж өгөхөө мартсан гэвэл түүн шиг худлаа зүйл үгүй. Хятадууд иим зүйлд хэзээ ч алдаа гаргадаггүй юм” гэж тус улсад хоёр ч удаа Элчин сайдаар ажилласан Мексикийн дипломатч Хорхе Гуаердо хэвлэлд ярьсан байна. Харин Нью-Йорк Таймс хятадууд зочдоо доромжилж буй хэлбэр хэмээн онцолжээ.

## Гюлины асуудлыг хэлэлцлээ

Их 20-ын бүлгийн уулзалтад оролцохоор Хятадын Ханзоу мужид зочилсон АНУ-ын Төрийн тэргүүн Барак Обама Туркийн Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдогантай хоёр талт уулзалт хийжээ. Тэдний уулзалтын гол сэдэв өнгөрсөн долдугаар сарын 15-нд Туркид гарсан цэргийн эргэлтийг хөшигний араас удирдсан гэх Фетуллах Гюлиныг шилжүүлэх асуудал байв. Уулзалтын үеэр Эрдоган АНУ-д орогнож буй Ф.Гюленыг Туркийн талд шилжүүлэн өгөхийг шаардсан байна. Туркид цэргийнхэн төрийн эргэлт хийхийг оролдсоноос хойш хоёр улсын төрийн тэргүүнүүд анх удаагаа нүүр нүүрээ харж уулзсан нь энэ байлаа.

Уулзалтын төгсгөлд хийсэн хэвлэлийн хурлын үеэр Эрдоган “Терроризм ямар ч хэлбэртэй байсан муу үр дагавартай” хэмээн онцлон тэмдэглэсэн байна. Тэрбээр мөн Гюлиныг дэмжиж буй хэнийг ч “Террорист бүлэглэл” гэж үзэхээ илэрхийлж, АНУ-ын талаас цэргийн эргэлтийг удирдсан эрхмийг шилжүүлэн өгөхийг шаарджээ. Түүнчлэн, Эрдоган цэргийн эргэлттэй холбоотой нотлох баримтыг АНУ-ын талд илгээнэ гэдгээ илэрхийлсэн байна. Харин Барак Обама “Хууль бус үйл ажиллагаанд оролцсон хэнийг ч шалгах, хариуцлага ногдуулахадхамтарчажиллана” гэдгээ амлажээ.

## “Шүхэрт хувьсгал”-ын төлөөлөгч сонгуульд яллаа

Хонконгод оюутнуудын зохион байгуулсан “Шүхэрт хувьсгал”-аас хойшхи анхны парламентын сонгууль зохион байгуулагдлаа. Сонгуулийн санал хураалт өнгөрөгч ням гарагт болсон бөгөөд өчигдөр гэхэд сонгуулийн дүн тодорхой болж эхэлсэн юм. Хонконгийн хууль тогтоох байгууллага 70 суудалтай. Тэгвэл энэ сонгуульд Хятадаас тусгаар тогтнохыг дэмжих радикал үзэлтэй ардчилагчид анх удаагаа парламентад олон суудал авах төлөв ажиглагдаж эхэлжээ. Гэхдээ тэд гол хууль тогтоомжийг өөрчлөхийн тулд парламентын гуравны нэгээс илүү суудал авах ёстой юм. Энэ удаагийн парламентын сонгууль сонгуулийн системийг өөрчлөхийг шаардсан 2014 оны томоохон хэмжээний “Шүхэрт хувьсгал”-аас хойш Хонконгийн хамгийн том сонгууль боллоо. Энэ удаагийн сонгуульд 2.2 сая хүн оролцон саналаа өгч, ирц 60 орчим хувьтай байжээ. Энэ нь түүхэн дэх хамгийн өндөр ирцтэй сонгуульд тооцогдож байна. Түүнчлэн, энэ сонгуульд Хятадаас тусгаарлах зорилго бүхий улстөрийн хүчнээс анх удаагаа иргэний хөдөлгөөний төлөөлөл нэр дэвшсэнээрээ онцлог байв. Санал тооллогын үйл ажиллагаа 90 гаруй хувьтай үргэлжилж байхад, радикал үзэлтнүүдээс гурван ч нэр дэвшигч ялалт байгуулах нь нэгэнт тодорхой болжээ. Тэдний нэг нь “Шүхэрт хувьсгал”-ыг удирдаж байсан оюутнуудын нэг 23 настай Натан Лау байв. Натан Лау “Демосисто” гэх шинэ улстөрийн намыг байгуулан сонгуульд оролцсон байна. Конконгийг бие даасан статустай болгох зорилго тавьснаас гадна Хятадаас салан тусгаарлах эсэх асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулахыг шаардаж байгаа. Натан Лау ялсныхаа дараа “Хонконг хүний хувьд сэтгэл зүрхнээсээ өөрчлөлтийг шаардаж байгаа” гэдгээ онцолсон байна. Энэ мэт ардчилагчид парламентын 70 суудлын гуравны нэг орчимд ялалт байгуулах төлөв ажиглагдаж байна.

## Тереза эхийг гэгээнтэнд өргөмжлөв

Энэтхэгийн Колката дахь ядуу ард иргэдэд тусламжийн гараа сунган тэтгэсэн энэрэнгүй үйлсээрээ дэлхий дахинаа алдаршсан Тереза эхийг Гэгээнтэнд өргөмжлөх ёслол зохион байгуулагджээ. Ёслолын үйл ажиллагаа Ватиканы Гэгээн Петерийн сүмд болсон бөгөөд 100 мянга гаруй католик шашинтнууд оролцсон байна. Харин гэгээнтэнд өргөмжлөх үйл ажиллагааг Ромын католикийн тэргүүн Францис гүйцэтгэжээ. Пап хэлэхдээ “хэл, соёл, арьсны өнгө болон шашин шүтлэгээс нь үл хамааран бүх хүнд ямар ч болзолгүйгээр хайр энэрлээ түгээх хэрэгтэй гэдгийг Тереза эх хүмүүст ойлгуулсан” гэжээ. Уг ёслолд оролцохоор хэдэн мянган хүн цугласан тус талбайд Тереза эхийн асар том зургийг байрлуулсан байв. Тереза эх 1910 онд одоогийн Македонид мэндэлсэн бөгөөд 18 настайдаа католик сүмийн цуглаанд явж эхэлж байжээ.

Энэтхэгийн ядуust тусалсан хүчин чармайлтыг нь өндрөөр үнэлэн 1979 онд түүнд Нобелийн Энхтайвны шагнал олгосон билээ. Түүнчлэн, 1985 онд АНУын Ерөнхийлөгч түүнийг төрийн дээд шагнал "Эрх чөлөөний" одонгоо хүртээн, хүндэт иргэнээ болгож байлаа. "Эрх чөлөөний" одонгоор АНУ-ын түүхэнд зургаахан хүн шагнагдсанаас ердөө хоёрхон нь амьд сэрүүндээ хүртсэний нэг нь Тереза эх, нөгөөх нь Английн Ерөнхий сайд асан вуинстон Черчилл гэнэ. Гэгээнтэн гэдэг бол өөрийнхөө ажил амьдралыг бусдад тусалж, католик шашны сургаалийг айлдахад зориулсан хүмүүст олгодог католик сүмийн хамгийн дээд цол юм. Хорт хавдартай энэтхэг эмэгтэй болон тархины хавдартай гэгдэж байсан бразил залууг Тереза эх эдгээж байжээ.


## ДАРААХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1256746 | ая0146068 | 1050146 | 0691143 | 1246420 | 148936 | 0406966 | 691844 | 302342 | 1086209 |
| 0275808 | 2207368 | 1154546 | 1109749 | 1258601 | 0348069 | 894983 | 161484 | 302322 | тя0675561 |
| 881440 | 170759 | 116537 | 1144639 | 1258551 | 160365 | 029169 | 161233 | 798361 | тя1067321 |
| 354768 | 1016727 | 882474 | 295819 | 824276 | 0156199 | 0213552 | 694112 | ая0700275 | 0697143 |
| 522635 | 0139738 | 842791 | 951955 | тя0982793 | 889274 | 0101491 | 232832 | ая0898090 | 1027685 |
| 1036485 | 1071553 | 687857 | 0229941 | 1235919 | 0609346 | 0673049 | 165025 | 815899 | 0654444 |
| 917449 | тя0511440 | 173944 | 908974 | 01111905 | 0718623 | 1057049 | 783641 | ая0185935 | 0291712 |
| 1196747 | Ая0171614 | 0596332 | ая0023698 | 0737871 | 0931180 | 1208424 | 691839 | ая0311652 | 00464051 |
| 855711 | 615192 | 0347441 | тя0746688 | 644921 | тя0687431 | 1280498 | 165292 | ая0622421 | 037748 |
| ая0748397 | тя01199091 | ая0716624 | тя0746691 | 1156236 | ат0135205 | 0988836 | 1266163 | 1259898 | 023339 |
| ая1214255 | 0730456 | 994424 | 9466268 | 0830952 | ая0224945 | 0758374 | 774337 | ая1053914 | 0728497 |
| ая0258908 | 0416494 | 1264620 | 2979609 | 1075537 | 655265 | 0758375 | тя0640177 | 159579 | 0421778 |
| ая1053674 | 0086533 | 154227 | 0608175 | 900478 | 732026 | 0724430 | тя0966759 | ая0713316 | 1107455 |
| ая0538080 | 0406958 | ТЯ0255561 | ая0204276 | 344274 | 1041426 | тя0383095 | тя1192288 | ая0724628 | 1267647 |
| ая0673689 | 1270001 | 0738879 | 0932584 | 1232173 | 193691 | тя1234503 | 0311763 | ая0399641 | 1273562 |
| ая0404209 | 1168196 | 1297077 | 909331 | 993113 | 804519 | 735902 | 0903254 | ая1199890 | 0572784 |
| ая0293841 | 1047890 | 0426290 | 1219017 | 0113083 | 347769 | 076643 | 119037 | ая0700187 | 1204636 |
| ая0599533 | 302145 | ая0119366 | 0113277 | 0884004 | 0563978 | тя0771880 | 263502 | ая0978060 | 166499 |
| 1065157 | 302135 | 781696 | 0274102 | 0937038 | 328956 | тя0916790 | 790933 | ая0472141 | 128713 |
| ач0000028 | 994945 | 355201 | ато364044 | 782084 | 966752 | тя01267327 | 180505 | ая1088713 | 0882817 |
| ая0958387 | 374900 | 355299 | 9492470 | 1127272 | ая0420083 | тя1072480 | ан0129056 | ая0958320 | 2413280 |
| 690174 | 0046650 | 764430 | 0988206 | 940922 | 1230881 | тя0127051 | 302206 | тя0999249 | тя0262225 |
| 714250 | 548293 | ая0198509 | 01234092 | 0904995 | 1250812 | 0141208 | 302229 | 0773754 | тя0262226 |
| аж0265022 | 615485 | 304856 | 1254222 | 0300223 | 962179 | 1203057 | 302256 | 0391134 | тя1077849 |
| тя124548 | 0209027 | 0957149 | 784111 | 1051256 | 0056907 | 1095580 | 302209 | 804797 | 0987685 |
| 599110 | 1225435 | ао0188087 | 122930 | 0725829 | 0057532 | 165282 | 302320 | 0679855 | тя1259137 |
| 422327 | 0350163 | тя0692224 | 1191604 | 231608 | 314699 | 666141 | 302358 | 0941671 | тя0982756 |

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## УРГАЦ ХУРААЛТАД ОРОЛЦОХЫГ ХҮССЭН ОЮУТАН СУРГУУЛЬДАА ХАНДАНА

Н.БАТЗАЯА

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд ургац хураалтын ажлыг эрчимжүүлэхийн тулд оюутан, залуусыг ургац хураалтад оролцохыг уриалсан билээ. Энэ талаар ХХААХҮ-ийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн М.Ариунболдоос зарим зүйлийг тодруууллаа.*

**-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайд П.Сэргэлэн оюутнуудыг “Орлоготой оюутан” хөтөлбөрт хамрагдаж, ургац хураалтад оролцохыг уриалсан. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Манай улсад өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ жил ургац арвин ургалаа. Гэвч ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс есдүгээр сард хөрсөн дээр цочир хүйтэрнэ гэдгийг тариаланчдад анхааруулж байна. Тэгэхээр энэ их ургасан ургацаа хурдан хугацаанд яаралтай хурааж авах шаардлага бидэнд тулгарч байгаа юм. Мэдээж үүнд хүн хүч хэрэг болно. Ганцхан газар тариалангийн компанийн ажилчид ургацаа хураана гэвэл хүч хүрэхгүй. Тиймээс Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн оюутан залуус болон дайчдад зориулж уриалга гаргасан. Энэ нь юу гэхээр эх орныхоо ажилд тусалж, ургац хураалтад оролцооч гэж уриалсан. Социолизмын үед намар болохоор л бүх нийтийн үйлс гэж сайхан ажлыг зохион байгуулдаг байсан. Тэгэхээр энэ сайхан уламжлалаа сэргээж, санаачлагатай ажиллая гэдэг уриалгыг л гаргасан юм. Энд нэг зүйлийг давтан хэлмээр байна. Сайд зөвхөн оюутан залууст хандаж уриалга гаргасан.

**-“Орлоготой оюутан” хөтөлбөрт хамрагдаж, цалинтай ажиллана гэсэн шүү дээ?**

-Зах зээлийн нөхцөлд ажиллаж байгаа учраас цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны байдал, орон байр, хоол хүнсээр хангах асуудал гарч ирнэ. Гэхдээ эдгээр асуудлыг зөвхөн аж ахуйн нэгж, оюутан, залуусын хоорондын гэрээгээр зохицуулах юм. Тэрнээс биш төсвөөс санхүүжилт гаргаад, цалингийн хөлсийг нь тогтоогоод оролцож байгаа зүйл байхгүй. Хэдэн оюутан авч, ямар хугацаанд ажиллуулах вэ гэдэг зөвхөн аж ахуйн нэгжийн л шийдэх асуудал. Тухайн оюутанг төмс хураалтын ажилд авах уу, тариа хураалтад авах уу гэдгээ мөн л аж ахуйн нэгж шийднэ. Ажил олгогч, оюутан хоёрын хооронд байгуулж байгаа гэрээ бий. Тэр гэрээгээрээ л зохицуулна. Харин сайдын хувьд бүх нийтийн үйлс шүү гэдгийг уриалж л байгаа юм. Социолизмын үеийн ургацан төв штаб шиг бүх хөдөлмөрийн фронт, нөгөө талаар ажиллах залуусын хүсэлтийг нийлүүлж, захиалгаар дисбючерийн үүрэг гүйцэтгэдэг зохион байгуулалт байхгүй. Зөвхөн тухайн оюутны хүсэл сонирхол дээр тулгуурлаж явагдана. Хэрвээ нэг оюутан ургац хураалтын ажилд оролцохыг хүсвэл оролцож болно. Тэрнээс биш нэгдсэн журмаар гэсэн ойлголт байхгүй.

> ...Энэ жил улсын хэмжээгээр 375.3 мянган га талбайд үр тариа, 22 мянган га талбайд төмс, хүнсний ногоо, 63.8 мянган га талбайд тосны ургамал, 25.3 мянган га талбайд тэжээлийн ургамал, 4.2 мянган га талбайд эмийн ургамалыг авна...

**-Одоогийн байдлаар оюутнуудтай гэрээ байгуулсан компани байгаа юу. Хэчнээн компани байна вэ?**

-Мэдэхгүй. Ямар ч байсан намрын ажил эхэлчихсэн. Ургац хураалтад цэргүүдийг авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгжүүд бий. Оюутнуудын хувьд мэдэхгүй. Оюутнууд Монголын оюутны холбоо, их, дээд сургуулийнхаа сургалтын албатай уулзаж, мэдээлэл авах хэрэгтэй.

**-Газар, тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэчнээн компани байдаг вэ?**

-Манай улсад бүтээний үйлдвэрлэл эрхэлдэг 1200 аж ахуй нэгж бий. Томоохон талбайтай 500-600, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг 370 гаруй аж ахуй нэгж байдаг. Хэчнээн нь оюутан сурагч авахаар захиалга өгснийг мэдэхгүй. Компаниуд шууд их, дээд сургуулиудтай хамтарч ажиллаж байгаа.

**-Ургац хураалтын ажил жигдэрсэн үү?**

-Энэ жил улсын хэмжээгээр 375.3 мянган га талбайд үр тариа, 22 мянган га талбайд төмс, хүнсний ногоо, 63.8 мянган га талбайд тосны ургамал, 25.3 мянган га талбайд тэжээлийн ургамал, 4.2 мянган га талбайд эмийн ургамалыг авна. Нийт 491.2 мянган га талбайд ургац хураалтын ажлыг зохион байгуулаад явж байна. Бэлтгэл ажил хангагдсан. Хураалтын ажил эхэлсэн. Ургац хураалттай холбогдуулан яаманд ургац хураалтын ажлыг зохион байгуулах үүрэг бүхий улсын комисс, орон нутагт салбар комиссууд байгуулагдсан. Одоогийн байдлаар ангилан хадалтын ажил жигдэрсэн.

## Газрын тос олборлодог компаниудад шалгалт хийлээ

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Газрын тос олборлодог, газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг, борлуулдаг байгууллага”-уудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтыг 2016 оны наймдугаар сарын 01-26-ны өдрүүдэд зохион байгууллжээ. Тус шалгалтад нийт 38 объект хамрагдаж, галын аюулгүйн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 325 тохиолдлыг илрүүлсэн байна. Мөн 51 зөрчил буюу 15.6 хувийг газар дээр нь арилгуулан, бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 28, мэдэгдэл хоёр, танилцуулга найм, ажиллагаа зогсоох тогтоол нэг, дүгнэлт гурвыг бичиж, байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн аж.

Түүнчлэн Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хуулийн 25 дугаар зүйл, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 251 дэх заалтыг үндэслэн нийт зургаан субъектыг 5.6 сая төгрөгөөр торгов. Батлагдсан удирдамжийн шалгалтын хугацаанд 16 байгууллагын нийт 188 хүнд гамшиг болон галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хоёр цагийн танхимын сургалтыг зохион явуулсан байна. Гал унтраах тактикийн сургуулийг Ойн бирж компанийн газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц 39 дүгээр салбар, Мон газ сервис ХХК-ийн агуулах, Сод монгол групп ХХК-ийн шатахуун түгээх станц 32, 37, 56 дугаар салбар, Ник Петровис ХХК-д зохион байгууллжээ. Мөн Багануур нефть хангамжийн салбар, Транс гайд сервис ХХК-ийн газрын тосны бүтээгдэхүүний агуулах зэрэг есөн объектод зохион байгуулж, тус тактикийн сургуульд Онцгой байдлын албаны гал унтраах зориулалтын 18 автомашин, нийт 262 албан хаагч, ажилтан, иргэд хамрагдсан оролцсон байна.

## Хяналтын цэг 24 цагаар ажиллаж байна

Малын гоц халдварт Шүлхий болон Цэцэг өвчин гарсантай холбогдуулан шалган бүртгэх товчоонд ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж байгаа билээ. Тэгвэл Замын цагдаагийн газраас Улаанбаатар хотыг тойрсон бүх хяналтын цэгүүд болон бусад нийслэл рүү чиглэсэн замууд дээр цагдаагийн алба хаагчдыг хүч нэмэгдүүлэн, 24 цагийн хяналт, шалгалт хийж эхэлжээ.

Мөн гоц халдварын бүс нутгаас нийслэл рүү зорчиж байгаа, дайран өнгөрөх авто машинаар шүлхий өвчин газар аван халдварлах боломжтой байдаг гэнэ. Иймд нийслэлийг тойрсон товчоодын дэргэдэх ариутгал халдваргүйжүүлэлтийн цэгүүдэд жолооч нар авто машинаа заавал халдваргүйжүүлэхийг сануууллаа.

## Нөхөн сэргээлт нэрээр ашигт малтмал олборлож байжээ

Сэлэнгэ аймгийн Ерөө, хүдэр сумд болон Бугант тосгоны нутаг дэвсгэрт нөхөн сэргээлт хийх нэрээр хууль бусаар ашигт малтмал олборлож байсан иргэн, аж ахуйн нэгжийг илрүүлжээ. Тус аймгийн цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны албадтай хамтарсан ажлын хэсэг байгуулж Хүдэр, Могойн голуудад газар дээр нь очиж үзлэг, шалгалтыг зохион байгуулсан байна. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх нэрийн дор хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан С захиралтай “Агро копт” ХХК нь Хүдэр сумын “Нуурын тагт” нэртэй газарт байгаль экологид 95 гаруй сая төгрөгийн хохирол учруулсан бол Ерөө сумын Могойн гол нэртэй газарт иргэн Б хууль бус аргаар ашигт малтмал олборлож байгаль экологид 10 гаруй сая төгрөгийн хохирол учруулжээ. Мөн Хүдэр сумын нутагт хууль бусаар ашигт малтмал олборлож, байгаль экологид 270 гаруй сая төгрөгийн хохирол учруулсан нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон иргэн Б-д хэрэг үүсгэх саналтайгаар прокурорын байгууллагад хүргүүлжээ. Байгаль орчинд хохирол учруулсан дээрх иргэд, ААН-үүд нөхөн сэргээлт хийх нэрээр холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авсан бөгөөд хамтарсан ажлын хэсэг гол ус бохирдуулан, хууль бусаар үйл ажиллагаа явуулсан дээрх хэргүүдийг үргэлжлүүлэн шалгаж байна.

PHOTO NEWS

*Баянзүрх дүүргийн хэсэг иргэд өнөөдөр УИХ-ын даргад хандсан бичгээ хүргүүлэхээр болжээ. Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны иргэн Д.Батдэлгэрээр итгэмжлүүлсэн 100 орчим иргэд өөрсдийн эзэмшлийн газрыг алдсан учир ийнхүү тэмцэхээр нэгдсэн байна. Тэд УИХ-ын гишүүн Б.Батзоригийг Баянзүрх дүүргийн Засаг дарга байхдаа эрх мэдэл, албан тушаалаа ашиглан өрсдийнх нь газрыг дээрэмдсэн хэмээн үзэж байгаа аж.*





*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД 28 ХҮН ОСОЛД ӨРТӨЖ, ГЭМТЛЭЭ

Өнгөрсөн амралтын өдрүүдэд зам тээврийн ослын улмаас 28 хүн гэмтсэн болохыг Улаанбаатар хотын Замын цагдаагийн газраас мэдээллээ. Хоёр хоногийн хугацаанд ЗЦГ-т нийт 564 дуудлага, мэдээ мэдээлэл хүлээн авснаас, зам тээврийн ослын 392 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 26 бүртгэгдсэн бөгөөд нэг хүний амь нас хохирч, 28 хүн хүнд хөнгөн гэмтжээ. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд холбогдсон жолооч тав, явган зорчигч нэг байгаа аж. Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 127 жолоочийг илрүүлж гарч болзошгүй осол хэргээс урьдчилан сэргийлж ажилласан байна. Тиймээс нийт иргэдэд замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцохыг холбогдох байгууллагаас анхааруууллаа.

## Шонхорын отгуудын үйл ажиллагааг зогсоов

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын хэлтэс, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газартай хамтран тус аймгийн Цэцэрлэг сумын Могойн голд шонхор барихаар төвхнөсөн отгийн үйл ажиллагаатай танилцжээ.

Хяналт, шалгалт хийх үед Пакистан, Сири, Кувейт зэрэг улсын дөрвөн иргэн, Монголын зургаан иргэний хамт Байгаль орчин аялал жуулчлалын яамны 2016 оны наймдугаар сарын 15-ны 06-136 тоот албан бичиг үзүүлж, таван идлэг шонхор барьсан байжээ. Тус отгийнхон 10 аймгийн нутгаас нийт 13 шонхор барих зөвшөөрөлтэй хэдий ч Хөвсгөл нутгаас хэдэн тооны шонхор барих ёстойг холбогдох байгууллагаас тодруулахаар үйл ажиллагааг нь түр зогсоосон гэж Хөвсгөл аймгийн МХГ-аас мэдээллээ.

NO STRESS

ООДЫН ЦАГ



# ЭРИ ТОСАКА:

Орчуулсан Б.ДАВАА

Бразилийн Рио де Жанейро хотноо болсон 31 дэх удаагийн зуны Олимпийн наадмын чөлөөт бөхийн 48 кг-ын жинд алтан медаль хүртсэн Японы бөх Эри Тосакагийн товчхон ярилцлагыг энэ удаагийн “Оддын цаг” буландаа орчуулан хүргэж байна. Эдүгээ 23 настай дэлхийн гурван удаагийн аварга тэрбээр алтын төлөө Азербайжаны бөх Мария Стадниктай таарч 3:2 гэсэн онооны харьцаатайгаар ялсан билээ.

# БАРИЛДААНЫ СҮҮЛЧИЙН МӨЧ ХҮРТЭЛ ГАГЦХҮҮ ЯЛНА Л ГЭЖ БОДСОН

**-Олимпоос алтан медаль хүртэх тамирчны нэгд та зүй ёсоор тооцогдож байсан. Тэр ч биеллээ олж Олимпоос алтан медаль хүртсэн шүү дээ. Таны яг одоогийн сэтгэгдлийг сонсмоор байна?**

-Таавартбагтаж байсан. Гэхдээ яг тэмцээн эхлээд барилдах тэр мөчид ялагдчих вий гэдгээс айсан шүү. Мэдээж алтан медаль авсан болохоор сэтгэл хангалуун байна.

**-Ердөө таван секунд үлдсэн байхад барилдааныг өөрийн талд эргүүлж чадсан. Тэр үед юу бодогдож байв?**

-Ямар ч байсан алтан медаль авах юм шүү гэж өөрийгөө зоригжуулж байсан. Барилдааны сүүлчийн мөч хүртэл гагцхүү ийм л бодолтой байлаа.

**-Сүүлийн алтан медалийн төлөөх барилдааны хоёрдугаар үед Азербайжаны бөх Мария Стадникээс илт давуу байх шиг санагдсан?**

-Анхнаасаа л аль аль тамирчин нь ялна гэсэн бодолтой барилдаандаа ордог. Тийм зүйл бодож сатаарахыг хүсээгүй.

**-Харүка Тачимотогоос медалийг нь авч үзэж байгаа харагдсан. Хүний медалийг харах, өөрөө тэр медалийг зүүх хоёрын ялгаа?**

-Ялгаатай байлгүй яах вэ. Харүка Тачимотогийн медалийг хараад “Би ч гэсэн аваргалчих юмсан” гэж битүүхэн цагаан атаархал тээж байснаа нуугаад яах вэ. Хүмүүс харахад энгийн нэг медаль боловч тамирчин хүний хувьд өнөөдрийг хүртэлх хөдөлмөр зүтгэлийнх нь шагнал байдаг юм. Тийм болохоор тэр алтан медаль надад их хүнд санагдсан.

**-Харүка Тачимототой ямар холбоотой юм бэ?**

-Бидний аавууд нэг ангийнх юм.

**-Аав тань ч гэсэн спортоор хичээллэдэг байх нь ээ?**

-Тэд хоёулаа жүдо бөхөөр хичээллэж байсан. Гэхдээ манай аав дунд сургууль хүртлээ л барилдсан.

**-Дараагийн олимп Токиод болно. Энэ удаагийн амжилтаа бататгахын тулд одооноос олимпдоо бэлтгэх үү?**

-Бэртэл авсан учир юун түрүүнд түүнийгээ эмчлүүлж, ирэх дөрвөн жилд барилдахад ямар нэг асуудалгүй болох хэрэгтэй . Дараа нь харин Токиогийн олимпид анхаарлаа төвлөрүүлж, бүх л хүчээ дайчлан бэлтгэлээ хийх болно.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 17
Шөнө 5

Нөгөөдөр
Өдөр 18
Шөнө 5

## Өдрийн зурхай

**Намрын дунд улаагчин тахиа сарын Нэг цагаан мэнгэтэй Цагаагчин туулай өдөр. Ангараг гараг**



*Өдрийн өнгө: Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, угаал үйлдэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хиймориин дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиаболой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.*

## Бидэнд тохиолдсон



### ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

### Batgerel Lkhagva

Манай хүү үеэл дүүгээ дагуулаад гадаа тоглож байгаад хэдэн хүүхдүүдээс зугтжээ. Хүү дүүгээ хаяад зугтаастай. Тэгсэн дүү нь газар унаад нүүрээ халцалчихаж. Гэтэл үеэл дүүгийн аав ээж нь хүүг маань загнаж л дээ. Хүү их гомдсон юм шиг байгаа юм. Аавдаа гомдоллож байснаа, “Аав, та тэд нарын Facebook дээр битгий Like дараарай” гэнэ ээ. Эхнэр бид хоёр баахан инээсэн

### Сувдаа Сувд

Охин маань нэг настай. Саяхан 20-иод хоногийн өмнө мөөмнөөсөө гарсан юм. Гэтэл уржигдар орой ТВ үзээд сууж байсан чинь “Ээдээ мээмээ мээмээ” гээд зурхайч Тэрбишийн цаг тооны бичгийг бариад ирлээ. Эхэндээ анзаарсангүй. Дахиад “Ээдээ мээмээ мээмээ” гээд байхаар нь сайн харсан чинь энэ цаг тооны бичгийн хавтас дээрх бич мөөмөө гаргачихсан байдаг байгаа. Тэрийг олоод харчихаж. Хэ хэ хэ. Охиноо өрөвдсөндөө уйлах, инээх хоёр зэрэгцлээ.

ДУУЛГАХ СОНИН

## “ICE-TOP” гэнэтийн бэлэг барина



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

О.ТӨРТОГТОХ

Монголын хип хопын томоохон төлөөлөл “ICE-TOP” хамтлагийн 20 жилийн ойн баяр энэ сард тохиож буй. Тэгвэл хамтлагийн гишүүд 20 насны төрсөн өдрөө энэ сарын 9-нд үнэнч сонсогчидтойгоо төв цэнгэлдэхийн их тайзнаа тэмдэглэх гэж байна. Тэд сүүлийн үеийн хөгжим, техник хэрэгслийг ашиглан бидний сэтгэлд аль хэдийнэ хоногшсон уран бүтээлээс эхлээд сонсч амжаагүй цоо шинэхэн уран бүтээлүүдийг хамтад нь эгшиглүүлэхээр төлөвлөж, тоглолтынхоо бэлтгэлийг базааж байгаа гэнэ. “Баярлалаа” нэртэй “Үргэлж хамтдаа” уриатай энэхүү тоглолтын тасалбарын үнэ 5000 төгрөг аж. Тасалбарыг www.iticket.mn –ээр захиалахаас гадна Улсын их дэлгүүр дэх явуулын кассаар захиалах боломжтой юм байна. “Бидний 20 жилийн тайзны амьдрал тантай ч бас холбоотой учраас сонсогч хүн бүрийг, Монголд хип хоп урсгалыг хөгжүүлж буй хамтлаг дуучин бүрийг урьж байна. Мөн бурханы оронд одсон Хаагийдаа зориулсан буяны үйлд тоглолтынхоо орлогоос зарцуулах болно. Бид найзынхаа ар гэрийнхэнтэй үргэлж холбоотой байдаг шүү” хэмээн “ICE-TOP”-ынхон онцолж байна. "Баярлалаа" хүндэтгэлийн тоглолтод "Clik Clik Boom", "Digital", "Vanquish", "Mon Ta Rap" зэрэг нэг цаг үеийн шилдэг төлөөлөл болсон хамтлагууд хүрэлцэн ирж ая дуугаа өргөх аж. Мөн тоглолтын дундуур 99 азтай үзэгчийг тодруулж, гэнэтийн бэлэг барих гэнэ.

## Ярден Жебри Олимпийн медалиа худалдаж, ӨВЧТЭЙ ХҮҮХДЭД ХАНДИВЛАЖЭЭ

Израилын жүдо бөхийн тамирчин Ярден Жерби олимпийн хүрэл медалиа худалджээ. Тэрбээр хорт хавдартай гэж оношлогдсон бага насны хүүхдийн эмчилгээний зардлыг олохын тулд Риогийн олимпоос авсан хүрэл медалиа дуудлагаар худалдсан бөгөөд түүний медаль 46700 еврогийн үнэ хүрсэн байна.

Тамирчин бүсгүй “Ebay” дуудлага худалдааны сайтад медалиа долоо хоногийн турш байрлуулсны эцэст дээрх хэмжээний үнэд хүрчээ. Улмаар Израилын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй хүүхдийн эмчилгээнд хандивлан буян үйлджээ. Ярден Жерби Риогийн олимпийн жүдо бөхийн 63 кг-ийн жинд зодоглон, Японы бөх Микү Таширог ялж, хүрэл медаль хүртсэн билээ. Мөн тэрбээр 2013 оны Жүдо бөхийн ДАШТ-аас алтан медаль хүртэж байв.


